



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Спортын ордон 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 94422277 Цахим хаяг: psosor@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.08 № 113
танай _____ -ны № _____ -г

ХАРХОРИН СУМЫН СПОРТЫН
ОРДНЫ ДАРГА Б.БАТДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Хархорин сумын Спортын ордны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сумын Спортын ордны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a circular emblem. The signature is written in a cursive style.

О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,015,738.00</u>	<u>9,750,100.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	8,015,738.00	9,750,100.00
351	Түүхий эд материал	4,899,900.00	6,019,900.00
35110	Тусгай зориулалттай материал	4,899,900.00	6,019,900.00
354	Хангамжийн материал	3,115,838.00	3,730,200.00
35410	Бичиг хэргийн материал	212,000.00	378,000.00
35420	Аж ахуйн материал	2,514,350.00	3,352,200.00
35450	Түлш, шатах тослох материал	389,488.00	-
37	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,217,441,826.25</u>	<u>4,336,256,169.35</u>
371	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
37110	Урт хугацаат хадгаламж	-	-
391	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,217,441,826.25	4,336,256,169.35
39201	Биет хөрөнгө	4,183,341,826.25	4,291,557,169.35
39202	Барилга, байгууламж, орон сууц	4,408,900,000.00	4,640,112,791.61
39203	Хуримтлагдсан элэгдэл	(297,041,666.71)	(404,259,868.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39205	Хуримтлагдсан элэгдэл		(3,333,333.36)
39206	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,087,400.00	35,087,400.00
39207	Хуримтлагдсан элэгдэл	(12,926,315.02)	(20,855,661.86)
39208	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,419,000.00	58,419,000.00
39209	Хуримтлагдсан элэгдэл	(19,164,052.02)	(26,680,618.50)
39210	Зам, гүүрийн байгууламж		
39301	Биет бус хөрөнгө	34,100,000.00	44,699,000.00
39302	Програм хангамж	500,000.00	500,000.00
39303	Хуримтлагдсан элэгдэл	-	(125,000.00)
39304	Бусад биет бус хөрөнгө	33,600,000.00	44,324,000.00
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,225,457,564.25</u>	<u>4,346,006,269.35</u>
41	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
51	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,222,390,104.25</u>	<u>4,342,938,809.31</u>
511	Засгийн газрын хувь оролцоо	4,222,390,104.25	4,342,938,809.31
51102	Өмч: - төрийн	33,600,000.00	44,324,000.00
51210	Хуримтлагдсан үр дүн	4,188,790,104.25	4,298,614,809.31
51220	Өмнөх үеийн үр дүн	4,231,438,471.91	4,188,790,104.25
51230	Тайлант үеийн үр дүн	(42,648,367.66)	109,824,705.06
51300	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51500	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,222,390,104.25</u>	<u>4,342,938,809.31</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	385,980,500.00	605,569,258.62
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,479,500.00	220,928,708.62
120	Нийтлэг татварын бус орлого	17,479,500.00	220,928,708.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,479,500.00	8,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,479,500.00	8,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,000,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		212,928,708.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,501,000.00	384,640,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,896,000.00	2,502,950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,896,000.00	2,502,950.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	365,605,000.00	382,137,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	365,605,000.00	382,137,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	439,128,867.66	495,744,553.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	439,128,867.66	495,744,553.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,681,592.69	491,902,303.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,925,734.00	113,860,291.00
210101	Үндсэн цалин	10,925,734.00	113,860,291.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,819,381.19	14,756,489.59
210201	Тэтгэврийн даатгал	9,420,717.26	10,240,090.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,109,246.98	1,137,814.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	887,397.58	910,251.84
210204	Ажилгүйдлийн даатгал	218,365.40	224,393.88
210205	Эрүүл мэндийн даатгал	2,183,653.97	2,243,938.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,413,741.40	238,692,993.56
210301	Гэрэл, цахилгаан	5,496,051.40	4,676,024.56
210302	Түлш, халаалт	196,106,050.00	229,023,849.00
210303	Цэвэр, бохир ус	4,811,640.00	4,993,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,401,662.00	5,573,008.00
210401	Бичиг хэрэг	1,076,050.00	830,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,793,712.00	1,789,488.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	547,050.00	705,270.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.00	244,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,254,850.00	1,512,250.00
210407	Аж ахуйн материал худалдан авах		

Хархорин сумын Спортын ордон 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	зардал		
210408	Бараа материал акталсны зардал		491,500.00
2105	Нормативт зардал	496,200.00	426,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	496,200.00	426,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,230,500.00	1,120,500.00
210604	Урсгал засвар	1,230,500.00	1,120,500.00
2107	Томилолт, зочны зардал	549,600.00	779,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	549,600.00	779,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,070,672.00	485,606.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	468,200.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		55,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		35,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		38,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		240,000.00
210807	Газрын төлбөр	278,472.00	117,606.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,774,102.10	116,208,415.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,941,100.00	8,370,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,833,002.10	107,838,365.56
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,447,274.97	3,842,249.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	565,000.00	1,790,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	565,000.00	1,790,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,882,274.97	2,052,249.85
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,882,274.97	2,052,249.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(53,148,367.66)	109,824,705.06
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(53,148,367.66)	109,824,705.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгөргөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	33,600,000.00	4,188,790,104.25	4,222,390,104.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,600,000.00	4,188,790,104.25	4,222,390,104.25

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
C07	Тайлант үеийн үр дүн			
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,600,000.00	4,188,790,104.25	4,222,390,104.25
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	33,600,000.00	4,188,790,104.25	4,222,390,104.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,600,000.00	4,188,790,104.25	4,222,390,104.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	10,724,000.00	0.00	10,724,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
D08	Тайлант үеийн үр дүн		109,824,705.06	109,824,705.06
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,324,000.00	4,298,614,809.31	4,342,938,809.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	375,980,500.00	392,640,550.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,479,500.00	8,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,479,500.00	8,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,479,500.00	8,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,479,500.00	8,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,501,000.00	384,640,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,896,000.00	2,502,950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,896,000.00	2,502,950.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	365,605,000.00	382,137,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	365,605,000.00	382,137,600.00
133004	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	3,880,000.00	640,015.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	357,762,500.00	389,640,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,762,500.00	389,640,550.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,315,225.03	385,798,300.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,247,860.00	113,860,291.00
210101	Үндсэн цалин	98,247,860.00	113,860,291.00
210102	Нэмэгдэл	12,000,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,573,381.63	14,756,489.59
210201	Тэтгэврийн даатгал	9,358,881.63	10,240,090.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,053,600.00	1,137,814.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	842,900.00	910,251.84
210204	Ажилгүйдлийн даатгал	210,700.00	224,393.88
210205	Эрүүл мэндийн даатгал	2,107,300.00	2,243,938.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,734,311.40	238,692,993.56
210301	Гэрэл, цахилгаан	5,496,051.40	4,676,024.56
210302	Түлш, халаалт	195,426,620.00	229,023,849.00
210303	Цэвэр, бохир ус	4,811,640.00	4,993,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,672,700.00	5,835,020.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,212,200.00	1,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	547,500.00	705,270.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.00	244,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,383,000.00	2,685,750.00
2105	Нормативт зардал	500,000.00	486,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	486,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	700,000.00	900,000.00
210604	Урсгал засвар	700,000.00	900,000.00
2107	Томилолт, зочны зардал	549,600.00	779,000.00
210702	Дотоод албан томилолт	549,600.00	779,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,070,872.00	485,606.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	468,400.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		55,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		35,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		38,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		240,000.00
210807	Газрын төлбөр	278,472.00	117,606.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,266,500.00	10,002,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,266,500.00	10,002,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,447,274.97	3,842,249.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	565,000.00	1,790,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал		

	урамшуулал	565,000.00	1,790,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,882,274.97	2,052,249.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,882,274.97	2,052,249.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,218,000.00	3,000,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,218,000.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,218,000.00	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,218,000.00	3,000,000.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,218,000.00	3,000,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(18,218,000.00)	(3,000,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373,560,600.0	373,084,500.0	390,137,630.0	390,137,600.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,560,600.0	373,084,500.0	390,137,630.0	390,137,600.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,560,600.0	373,084,500.0	390,137,630.0	390,137,600.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,362,800.0	110,247,860.0	114,000,000.0	113,860,291.0
210101	Үндсэн цалин	98,362,800.0	98,247,860.0	114,000,000.0	113,860,291.0
210102	Нэмэгдэл	12,000,000.0	12,000,000.0		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,224,000.0	13,573,381.6	15,390,000.0	14,756,489.6
210201	Тэтгэврийн даатгал	14,224,000.0	9,358,881.6	10,830,000.0	10,240,090.3
210202	Тэтгэмжийн даатгал		1,053,600.0	1,140,000.0	1,137,814.8

Хархорин сумын Спортын ордон 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	-	842,900.0	912,000.0	910,251.8
210204	Ажилгүйдлийн даатгал	-	210,700.0	228,000.0	224,393.9
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,107,300.0	2,280,000.0	2,243,938.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,189,200.0	205,734,311.4	239,602,800.0	238,692,993.6
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.0	5,496,051.4	5,335,000.0	4,676,024.6
210302	Түлш, халаалт	202,249,200.0	195,426,620.0	228,267,800.0	229,023,849.0
210303	Цэвэр, бохир ус	5,440,000.0	4,811,640.0	6,000,000.0	4,993,120.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,670,200.0	5,670,200.0	5,466,830.0	5,126,070.0
210401	Бичиг хэрэг	800,000.0	800,000.0	800,000.0	800,000.0
210402	Тээвэр, шатахуун	2,212,200.0	2,212,200.0	1,400,000.0	1,400,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	520,000.0	520,000.0	840,000.0	505,270.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.0	250,000.0	250,000.0	244,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,888,000.0	1,888,000.0	2,176,830.0	2,176,800.0
2105	Нормативт зардал	500,000.0	500,000.0	150,000.0	150,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.0	500,000.0	150,000.0	150,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,572,000.0	17,556,000.0	3,900,000.0	3,900,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,872,000.0	16,856,000.0	3,000,000.0	3,000,000.0
210604	Урсгал засвар	700,000.0	700,000.0	900,000.0	900,000.0
2107	Томилолт, зочны зардал	650,000.0	549,600.0	800,000.0	779,000.0
210702	Дотоод албан томилолт	650,000.0	549,600.0	800,000.0	779,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,092,400.0	1,070,872.0	378,000.0	377,606.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	468,400.0	468,400.0		
210803	Даатгалын үйлчилгээ	324,000.0	324,000.0	55,000.0	55,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар			35,000.0	35,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			38,000.0	38,000.0

Хархорин сумын Спортын ордон 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			132,000.0	132,000.0
210807	Газрын төлбөр	300,000.0	278,472.0	118,000.0	117,606.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
		10,000,000.0	10,000,000.0	9,850,000.0	9,842,900.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.0	10,000,000.0	9,850,000.0	9,842,900.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
		300,000.0	300,000.0	600,000.0	2,652,249.9
2132	Бусад урсгал шилжүүлэг				
		300,000.0	300,000.0	600,000.0	600,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.0	300,000.0	600,000.0	600,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		7,882,275.0	-	2,052,249.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,882,275.0		2,052,249.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		373,560,600.0	373,084,500.0	390,137,600.0	390,137,600.0
120	Нийтлэг татварын бус орлого				
		8,000,000.0	7,479,500.0	8,000,000.0	8,000,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,000,000.0	7,479,500.0	8,000,000.0	8,000,000.0
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.0	7,479,500.0	8,000,000.0	8,000,000.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		365,560,600.0	365,605,000.0	382,137,600.0	382,137,600.0
132001	Орон нутгийн төсвөөс	365,560,600.0	365,605,000.0	382,137,600.0	382,137,600.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
				-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
		-	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
				12	12
620001	Удирдах ажилтан			1	1
620002	Гүйцэтгэх ажилтан			8	8
620003	Үйлчлэх ажилтан			3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,502,950.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,502,950.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,312,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	708,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	508,950.00
2105	Нормативт зардал	336,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	336,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	108,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,190,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,190,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,190,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,502,950.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,502,950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,502,950.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин сумын Спортын ордны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Чадварлаг аудит ХХК-ийн аудитор П.Сосорбурам гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01-р сарын 18-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Орон нутагт биеийн тамир спорт хөгжих орчин нөхцлүүдийг бүрдүүлэн эрүүл чийрэг бие бялдартай иргэн хамт олныг төлөвшүүлж биеийн тамир спортыг нийтийн хүртээл болгон сонгон хөгжүүлж буй спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлэн өндөр цол зэрэгтэй тамирчдыг бэлтгэнэ.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт-1. Төрийн үйлчилгээний удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан, ордны өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн, чадварлаг аппарат бүрдүүлэх

Зорилт-2. Ордны чиг үүрэгтэй холбоотой гарсан хууль тогтоомж, бодлогын зорилт, тусгай захиалгат ажлын биелэлтийг тайлагнан, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах

Зорилт-3. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу үр ашигтай зарцуулж зарцуулалтын тайлан мэдээг сар улирал бүрээр төсвийн тухай хуулийн дагуу тайлагнаж мэдээлэх

Зорилт-4. Ордны тохижилт үйлчилгээ материаллаг баазыг бэхжүүлж ажилчдын ажлын байрыг сайжруулах ажлын хүрээнд Тэргүүлэх чиглэлийн 4 төрлийн спортын тамирчдын бэлтгэл хийх ая тухтай орчин бүрдүүлэх тамирчдын амжилтыг ахиулах.

Зорилт-5. Ордны чиг үүрэгтэй холбоотой гарсан хууль тогтоомж, бодлогын зорилт, тусгай захиалгат ажлын биелэлтийг хангуулж тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус сургуулийн бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Дотоод хяналтын нэгжийг 3 хүний бүрэлдэхүүнтэй 2021 оны 01-р сарын 20-ны А/03 тоот тушаалаар томилон байгууллагын дотоод хяналтын журмыг мөрдөн ажилладаг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Спортын ордны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 495.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн ИТХ-н 79-р тогтоолоор 231212.8 сая төгрөгийн заалны барилга, 10.7 сая төгрөгийн заалны барилгын газар тус тус нэмэгдсэн. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь өөрийн орлого 8.0 сая төгрөгбайна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 382.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 390.1 сая төгрөгөөр санхүүжүүлжээ. Санхүүжилт өмнөх оноос 4.5 хувиар өссөн байна. Энэ нь дулааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 390.1 сая төгрөгөөр санхүүжигдэн, 390.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон өөрийн нэмэлт орлого 2.5 сая төгрөг байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос, бараа үйлчилгээний зардалд 1.3 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, шагнал урамшуулалд 1.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлангуудыг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сар бүр, тухай бүр, улирал бүр, бүтэн жилээр мэдээг цаг хугацаанд нь тогтмол мэдээллээ шилэн дансанд байршуулдаг.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Хархорин сумын Спортын ордон нь 2021 онд 150 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас 146 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 3 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож,

нийт мэдээллийн 99.7 хувийг хугацаандаа, 0.3 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь дулаан халаалтын зардлыг өссөн дүнгээр шилэн дансанд 6 дугаар сараас бусад сард байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр байршуулах гэсэн заалтийг зөрчсөн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөрчил илэрээгүй учраас 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй “Итгэл үзүүлсэн” байна

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны тухай хуулийн заалт бүрийг бүрэн хэрэгжүүлж, мэдээлэлийг тогтмол оруулж байх

4. Аудитын илрүүлэлт

Дулаан халаалтын зардлыг өссөн дүнгээр шилэн дансанд 6 дугаар сараас бусад сард байршуулаагүй 101.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

4.3 Албан шаардлага

Байхгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байхгүй болно.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хархорин сумын Спортын ордон	1	101.6	0	0	0	0	0	0	1	101.6

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

П.СОСОРБУРАМ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 09-НЫ ӨДӨР